

МОНГОЛЫН ЦАХИМ СЭТГҮҮЛ ЗҮЙН ХӨГЖИЛ, ХАНДЛАГА,
ТУЛГАМДСАН АСУУДЛУУД

Б.Наранбаатар*

* МУИС, НШУС, Сэтгүүл зүйн тэнхмийн багш, магистр, докторант

Түлхүүр үг: мэдээллийн нийгэм, даяаршил, Интернет, цахим сэтгүүл зүй, "Цахим Монгол" хөтөлбөр, ОНМХ-ийн систем.

Аж үйлдвэржсэн эринээс мэдээлэлжсэн эринд шилжих үйл явц дэлхийн улс орнуудад улам бүр эрчимжин, мэдлэгт тулгуурласан нийгмийг цогцлоон байгуулж, нийгмийн баялаг, үнэт зүйлсийг бий болгох эх сурвалж нь мэдлэг, мэдээлэл гэдгийг дэлхий нийтээр хүлээн зөвшөөрч, улс төр, эдийн засаг, нийгмийн бүхий л хүрээнд мэдээлэл, харилцаа холбооны технологийг өргөнөөр нэвтрүүлэн хэрэглэж байна.

Дэлхий ертөнц даяаршин буй 21-р зуунд мэдээллийн технологийн хөгжлийн төвшин улс орон бүрийн олон улсын төвшинд эзлэх байр суурь, цаашдын хөгжлийг тодорхойлох үндсэн гол хүчин зүйл болно. Мэдээллийн эрин зуунд Монгол Улс бусадтай хөл нийлүүлэн хөгжихэд холбоо харилцаа,

мэдээллийн шинэ технологи, цахим сэтгүүл зүйн гүйцэтгэх үүрэг нөлөө маш чухал.

Иймд дэлхийн болон Монголын төвшинд цахим сэтгүүл зүйн хөгжил, цаашдын хандлагыг тодорхойлон дүгнэж, харьцуулах, үнэлэх, шүүмжлэх зэргээр улам боловсронгуй, ач холбогдолтой, үр дүнтэй байлгахад энэ чиглэлийн судалгаа шинжилгээний цар хүрээг өргөсгөн гүнзгийрүүлэх, сургалтын хөтөлбөр, практикт нэвтрүүлэх зайлшгүй шаардлага урган гарч байна.

Монголын ОНМХ-ийн систем дэх цахим сэтгүүл зүйн эзэлж буй, эзлэх ёстой байр суурийг тодорхойлохын өмнө мэдээллийн эрин, мэдээлэлжсэн нийгэм, цахим сэтгүүл зүй гэх мэт ухагдахууныг нарийвчлан тайлбарлах, нэгдсэн ойлголтод хүрэх нь зүйтэй.

Даяаршлын үйл явц хурдасч, дэлхий нийтээр компьютер, тоон технологи, интернетийн дэвшил, шинэ соргог бүхний ач холбогдолыг мэдрэн, ашиглах болсон өнөө үед дэлхийн улс

орнууд мэдээллийн нийгмийн шинж чанарыг агуулах болсон.

Мэдээллийн нийгэм гэдэг нэр томъёог анх Токиогийн технологийн их сургуулийн профессор Ю. Хаяши хэрэглэн тодорхойлсон бөгөөд глобальчлал буюу даяаршлын хамгийн гол хүчин зүйл, шинж чанар хэмээн эрдэмтэн судлаачид дүгнэж буй. Монголд энэхүү нэр томъёог мэдээллийн эрин, мэдээлэлжсэн нийгэм гэсэн ухагдахуунуудтай адилтган, ижил утгаар ярих, хэрэглэх нь бий. Мэдээллийн буюу мэдээлэлжсэн нийгмийг цогцлоон байгуулсан, эсвэл байгуулахаар аливаа улс орон зорьж буй үеийг цаг хугацааны хувьд "эрин" хэмээн тодорхойлбол зохистой. Профессор Ю.Хаяшигийн дүгнэснээр мэдээллийн нийгэм нь дараах үндсэн шинж чанаруудыг агуулах ёстой. Үүнд:

- Бараа таваар үйлдвэрлэлтээс үйлчилгээ рүү чиглэсэн эдийн засгийн хандлага.
- Үйлдвэрлэл, технологийн салбарт оюуны өмч, хөдөлмөр, түүний үр дүнг дээдэлдэг.
- Нийгмийн үнэт зүйлсийн системд материаллаг зүйлийн байр суурь багассан.
- Мэдлэг, мэдээлэл бол нийгэм, улс төр, эдийн засаг, технологийн салбарт үндсэн гол үзүүлэлт болсон.
- Соёл боловсролын салбарын үнэлэмж, үйл ажиллагааны зарчим өөрчлөгдөн хувь хүний ёс суртахуун,

оюуны чадамж, бололцоо, үр ашигт тулгуурласан байх.

- Нийгмийн бүх салбарын мэдээлэл, мэдлэгийг дамжуулах арга технологи системжсэн, харилцаа шүтэлцээ уялдаа холбоо нь нарийвчлагдсан байх гэх мэт болно.

Нийгмийн төлөвшил, улс төрийн гадаад байр суурь, чиг баримтлал, эдийн засгийн хөгжлийн төвшин зэргээс үл хамааран дэлхийн нийтээр мэдээллийн эриний давалгаанд автан улс орон бүр мэдээллийн нийгмийг байгуулахын чухлыг мэдэрч байна.

Дэлхийн ихэнх улс орнууд өнгөрсөн зууны сүүлчээс эхлэн мэдээлэл, харилцаа холбооны технологийг хөгжүүлэх урт, богино хугацааны стратеги хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх болсон нь үүний тод жишээ. Тухайлбал, Сингапурын "Ухаалаг арал" хөтөлбөр, БНСУ-ын "Мэдээллийн дэд бүтэц" үндэсний төлөвлөгөө, Малайзын "Мултимедиа супер коридор" хөтөлбөр, Япон улсын "Цахим Япон" гээд олон хөтөлбөрийг энд дурдаж болно. Үүнээс гадна, Их Британи, Франц, Герман зэрэг Европын улс орнуудын энэ чиглэлд зарцуулахаар төлөвлөдөг хөрөнгийн хэмжээ нь жил бүр өсөн нэмэгдэж, өдгөө 1-1,3 тэрбум ам. долларын санхүүжилт мэдээллийн салбарт хийгдэх болов.

Монгол Улсын хувьд ч мэдээлэл, харилцаа холбооны технологийн давуу хэрэглээг бүрдүүлж, түүнийг улс орны

хөгжлийн хурдасгуур болгон Засгийн газрын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл болгох шаардлага зүй ёсоор гарч, "Цахим Монгол" үндэсний хөтөлбөрийг боловсруулан дунд хугацаанд буюу 2005-2012 онд хэрэгжүүлж эхлэв.

Долоон жилийн хугацаанд мэдээлэл, харилцаа холбооны салбарын хууль, эрх зүйн тогтолцоог бүрдүүлж, дэд бүтэц, сургалт судалгааны асуудлыг шийдвэрлэн, хөтөлбөрийн хэрэгжилтэнд шат дараалалтай хяналт тавьж, үр дүнг тооцож байх үүрэгтэйгээр Засгийн газрын тохируулагч агентлагийг бий болгосон. "Цахим Монгол"

хөтөлбөрийн хүрээнд 20 орчим дэд хөтөлбөр буюу чиглэлийг тодорхойлж, "Цахим засаглал", зайны сургалт, эмчилгээ, интернет худалдаа, арилжаа, 33 нэгж хүн амын мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх гэх мэт үйл ажиллагаа төлөвлөгдөн, нийт 134 тэрбум гаруй төгрөг зарцуулагдана хэмээн МХХТГ-ын мэргэжилтнүүд тооцоолжээ.

Мэдээллийн технологи, хөгжил дэвшлийн шинэ соргог бүхнийг нийт иргэдэд таниулах "Цахим Монгол" хөтөлбөрийн хэрэгжилтэд түлхэц өгөх, чаашлаад Монгол улс мэдээллийн

эринд шилжихэд ОНМХ-үүд, сэтгүүлчдийн оролцоо, хамтын ажиллагаа чухал үүрэгтэй. Энэ нь дэлхийн улс орнуудын мэдээллийн харилцаанд "хүч түрэн" орж ирсэн цахим сэтгүүл зүйн хөгжилд анхаарал хандуулах, ач холбогдол өгөх зайлшгүй шаардлага

үүссэнийг бидэнд сануулж буй юм.

1960-аад оноос, тодорхой хэлбэл, 1969 онд АНУ-д цэргийн мэдээллийн сүлжээний зоориулалтаар АРПА-НЕТ нэртэйгээр үндэс сууриа тавьсан интернет 80-аад оны дундаас дэлхийн улс орнуудад тархаж, удалгүй улс

төр, нийгэм, эдийн засаг, шинжлэх ухаан гээд бүх салбарт амин чухалд тооцогдох мэдээллийн сүлжээ, холбоо харилцааны шинэ орчин болон төлөвшсөн юм.

Аливаа нийгмийн мэдээллийн харилцааны томоохон цөм болохын хувьд сэтгүүл зүйн салбар хамгийн түрүүнд, хамгийн идэвхтэйгээр интернетжиж эхэлсэн гэхэд болно. ОНМХ-ийн уламжлалт хэлбэрүүд, сэтгүүл зүй онол, баримтлал, тэр дундаа сэтгүүлчдээс үл хамааралтайгаар мэдээлэл түргэн шуурхай солилцох, олон нийтэд хүргэх шинэ урсгал бий болсон нь

«

Мэдээллийн нийгэм гэдэг нэр томъёог анх Токиогийн технологийн их сургуулийн профессор Ю. Хаяши хэрэглэн тодорхойлсон бөгөөд глобальчлал буюу даяаршлын хамгийн гол хүчин зүйл, шинэ чанар хэмээн эрдэмтэн судлаачид дүгнэж буй. Монголд энэхүү нэр томъёог мэдээллийн эрин, мэдээлэлжсэн нийгэм гэсэн ухагдахуунуудтай адилтган, ижил утгаар ярих, хэрэглэх нь бий.

»

аяндаа ОНМХ-үүд цахим хувилбартай болох, интернет сонин хэвлэл, мэдээлэл хайлтын системийг бүрдүүлэх шаардлага үүсч, цаашлаад цахим сэтгүүл зүй хэмээх шинэ ойлголтыг төрүүлсэн байна.

Дээрх хандлага ерөнхийдөө интернет, цахим технологи хөгжиж буй бүх улсад ижил дүр зураг харуулдаг. Өдгөө бидний "цахим" хэмээн тодорхойлсон сэтгүүл зүй шинэ чиглэл, хэлбэрийг гадаад дотоодод интернет сэтгүүл зүй, веб-сэтгүүл зүй, on-line сэтгүүл зүй гэхчлэн олон янзаар нэрлэж буй бөгөөд бүгд ижил утга агуулж байгааг тэмдэглэх нь зүйтэй. Зүүн-Өмнөд Ази, Европын улс орнууд, АНУ-д цахим сэтгүүл зүйн хөгжил өндөр төвшинд хүрсэн ба энэ чиглэлийн судалгаа шинжилгээ ч их хийгдэх болов. Цахим сэтгүүл зүйн үүсэл, хөгжил, хандлагын талаар өдгөө олон төрлийн байр суурь, үзэл баримтлалыг дурдах боломжтой. Тухайлбал, Москвагийн Их сургуулийн профессор Л.Коханова "Цахим сэтгүүл зүй" номондоо бичихдээ: "Интернет 90-ээд оны дундаас улам бүр хөгжин, цар хүрээгээ тэлэхийн хэрээр өөрөө цахим сэтгүүл зүйг бий болгосон бөгөөд ОНМХ-үүд, уламжлалт сэтгүүл зүйн онолчид, сэтгүүлчид бүр сүүлд нь, өөрөөр хэлбэл, интернет тэдний амьдралд "хүч түрэн" орж ирэх үед сэтгүүл зүйн шинэ үзэгдэл, шинэ төрөл зүйл, чиглэл гэдгийг хүлээн зөвшөөрч эхэлсэн" гэжээ. Үнэхээр ч уламжлалт

ОНМХ-үүд анхны цахим хувилбарууд 1995-1996 онд үүсч, интернет ХМХ-үүд үүнтэй зэрэгцэн үйл ажиллагаагаа эхэлсэн боловч одоогоос 6-8 жилийн өмнөөс л жинхэнэ утгаараа сэтгүүл зүйн шинэ үзэгдэл болон төлөвшиж, байр сууриа бататгасаар ирлээ. Харин судалгаа, шинжилгээний хувьд үүнээс хожуу буюу 3-4 жилийн өмнөөс эх сууриа тавьж, өдгөө энэ чиглэлээр мэргэжилтэн бэлтгэх, сургах, сургалтын хөтөлбөрт оруулах асуудал яригдах болжээ.

Монгол Улсын хувьд анх 1994 онд цахим шуудангийн, 1996 оноос интернетийн үйлчилгээ нэвтэрч одоогоор Magicnet, Миком, Мобиком, Бодиком, MSC, SKY, С, Winet, Ulusnet гэх мэт 20 шахам компани интернетийн үйлчилгээг эрхэлж байна.

2000 оноос эхлэн Монголд интернет үйлчилгээ, программ хангамж, цахим сүлжээний технологи эрс сайжирч, төрийн болон төрийн бус байгууллагууд өөрсдийн байнгын веб хуудас ажиллуулж, банк санхүү, арилжаа, худалдааны салбарт цахим технологи өргөн тархаж, энэ төрлийн үйл ажиллагааны цар хүрээ, нэр төрөл эрчимтэй өсч байна. "Монголын хөгжлийн гарц" ТББ-ын явуулсан судалгаагаар идэвхтэй ажиллаж буй 1500 гаруй монгол веб-сайт байгаагаас 50,4% нь хувийн хэвшлийнхэнд, 30,7% нь олон нийтийн ашгийн бус байгууллагад, 9,8% нь хувь

хүмүүст, 9,1% нь төрийн байгууллагуудад харьяалагддаг байна.

Мөн интернетийн 220 мянган хэрэглэгч бий аж. Гэхдээ энэ бол 2003 онд хийгдсэн судалгаа. Тухайн үед үүрэн телефоны хэрэглэгчдийн тоо 450 орчим байсан. Харин саяхан үүрэн телефоны үндэсний операторууд нэг сая дахь хэрэглэгчээ бүртгэж авлаа хэмээн мэдээлж байснаас үзвэл интернетээр үйлчлүүлэгчдийн тоо ч төдий чинээ хувиар нэмэгдсэн байх магадлалтай.

Үүнээс үзэхэд Монголд цахим сэтгүүл зүй цаашид хөгжих, цар хүрээ, үр нөлөөгөө ихэсгэх үндэс суурь хэдийнэ тавигдсан ба өнөөгийн хөгжлийн төвшинг тодорхойлох баримт, материал хангалттай бүрэлдэн, судалгаа шинжилгээний шинэ содон сэдэв болсон гэж үзэж байна.

Өнөөгийн байдлаар Монголын үндэсний болон нийслэлийн хэмжээний ихэнх ОНМХ-үүд өөрийн веб-сайттай ба үүгээрээ дамжуулан мэдээ мэдээллээ цаг хугацаа, орон зайн хязгаарлалтгүйгээр хүргэх боломж бүрдсэн. Мөн цэвэр интернетийн мэдээллийн хэрэгслүүд, хайлтын системүүд ажиллаж буй нь цахим сэтгүүл зүйн агуулга, шинж чанарт бүрэн нийцэж, хамрах хүрээг томруулж байгаа юм.

Интернетийн ОНМХ-ийн системд авчирч буй ололт дэвшилтийг багцлан тооцвол:

1. Сэтгүүл зүй эргэх холбоотой болсон. Цахим технологийн ачаар сэтгүүл зүй жинхэнэ утгаараа "иргэний" шинж чанараа олж, уншигч үзэгчидтэйгээ эргэх холбоотой ажиллах боломж бүрдсэн.

2. Сэтгүүл зүй, хувь хүний эрх ашигт нийцэх болсон. Нэг болон хэсэг бүлэг хэрэглэгчид зориулсан, тэдний эрх ашгийг тусгасан нийтлэл нэвтрүүлэг гаргах боломж бий болов.

3. Сэтгүүл зүй мэдээлэл төвтэй болсон. Өөрөөр хэлбэл, нэг болон нийт ОНМХ-ийн мэдээлэл нэгдсэн санд багтсанаар хэрэглэгч мэдээллийг өөрт хэрэгтэй төвшинд, өөрт хэрэгтэй хэмжээгээр хүртэх бололцоог олгож байна.

4. Сэтгүүл зүй гэрлийн хурдтай болсон. Интернетийн үйлчилгээ хямдарч, цахим технологи нэвтрэхийн хэрээр ОНМХ-ийн мэдээлэл тархах, олон нийтэд хүрэхэд цаг алдахгүй болсон.

5. Сэтгүүл зүй хэмжүүртэй болсон. Веб сайтууд автомат тоологчийн тусламжтайгаар ямар нийтлэл, ямар сэтгүүлч, цаашлаад ямар мэдээллийн хэрэгсэл эрэлттэй, нэр хүндтэй байгааг тодорхойлох боломжтой.

6. Сэтгүүл зүй уян хатан болсон. Цахим мэдээллийн хэрэгслийн мэдээлэл, веб хуудасны загвар, байршил зэргийг тодорхойлох, шинэчлэх явцад хэрэглэгч "гар бие" оролцох бололцоо нээгдсэнээр байнгын сонирхол төрүүлнэ.

7. Сэтгүүл зүй хямд болсон. Уламжлалт ОНМХ-үүдтэй харьцуула-

хад цахим мэдээллийн хэрэгсэл үүсгэн бий болгох, мөн хэрэглэгчийн зүгээс мэдээлэл олж авах явц эрс "хямдарсан".

Дээрх жагсаалтыг цааш үргэлжлүүлэх бүрэн боломжтой ба цахим сэтгүүл зүйн ерөнхий хандлагад тулгуурласан болно.

Цахим сэтгүүл зүйн гол онцлог нь уламжлалт ОНМХ-үүдийн мэдээлэл дамжуулах арга, техник технологийг бүгдийг нэгтгэж чадсанд оршиж буй бөгөөд текст аудио, видео материалуудын багц санг бий болгосноор хэрэглэгчдэд өргөн сонголт, хязгааргүй боломжийг нээж байна. Барууны зарим

судлачид цахим сэтгүүл зүйн хөгжил уламжлалт ОНМХ-үүд болох сонин, сэтгүүл, радио, телевизийн ирээдүйд муу нөлөөтэй хэмээн баталдаг.

Учир нь олон нийтийн харилцааны ололт амжилт бүхнийг агуулсан интернет ямар ч үзэгч, уншигч, сонсогчийг байлдан дагуулах, улмаар уламжлалт ОНМХ-үүдээс татгалзахад хүргэж болох юм гэж үздэг. Гэвч одоогоор дэлхий улс орнуудын компьютержсэн, интернетийн сүлжээнд холбогдсон, иргэдийн хэрэглэж заншсан байдал

тийм төвшинд хүрэхэд хол байгааг харуулна.

Монголын ОНМХ-ийн систем дэх цахим сэтгүүл зүйн хөгжил өөрийн гэсэн өнгө аяс, онцлогуудтай байгааг тэмдэглэх хэрэгтэй. Сэтгүүл зүйн хөгжилд интернетийн олгож буй дээр дурдсан дэвшлүүд Монголын цахим сэтгүүл зүйд янз бүрийн төвшинд ажиглагдаж байгаагаас гадна мэдээллийн эх сурвалж аудиторийг татах шинэ талбарын үүрэг гүйцэтгэх болсныг нэрлэж болно.

Гадаад мэдээ, олон улсын үйл явдлыг түргэн шуурхай мэдээлэх, аливаа мэдээлэлд дүн шинжилгээ хий-

хэд нэмэлт эх сурвалж олох зорилгоор гадаад болон дотоодын цахим мэдээллийг ашиглах явдал сэтгүүлчдийн дунд дэлгэрч буй нь сайшаалтай зүйл юм.

Мөн гадаад улс оронд сурч, ажиллаж, амьдарч буй болон мянган монгол иргэд цахим мэдээллийн хэрэгслүүдийн зонхилох аудиторийг бүрдүүлээд зогсохгүй, оршин суугаа улс орон, хөтуудын нутаг нэгтнүүдийн хамт веб хуудас ажилуулан мэдээллийн далайд шинэ цутгал нэмэх болсон.

«

Монголын ОНМХ-ийн систем дэх цахим сэтгүүл зүйн хөгжил өөрийн гэсэн өнгө аяс, онцлогуудтай байгааг тэмдэглэх хэрэгтэй.

Сэтгүүл зүйн хөгжилд интернетийн олгож буй дэвшлүүд Монголын цахим сэтгүүл зүйд янз бүрийн төвшинд ажиглагдаж байгаагаас гадна мэдээллийн эх сурвалж аудиторийг татах шинэ талбарын үүрэг гүйцэтгэх болсныг нэрлэж болно.

»

Цахим сэтгүүл зүйг Монголд цаашид хөгжүүлэх, ач холбогдол, үр нөлөөг нь дэлгэрүүлэн тэлэх, улам боловсронгуй болгох хүсэл эрмэлзэл, шаардлага, үүрэг бидэнд бий. Цахим сэтгүүл зүйн ирээдүйн ач тус, ололт дэвшлийн үр, шимийг олж харахад амархан ч, шийдвэрлэх асуудлууд, тулгарч буй хүндрэлүүд багагүй.

Улс орны эдийн засгийн хөгжил, чадамж, нийт хүн амын амьжиргааны төвшин, дэд бүтцийн хөгжил, шинэ техник технологи хөдөө орон нутагт нэвтэрсэн байдал, нийт иргэд компьютержсэн, компьютер эзэмших чадварын төвшин зэргээс хамаарч мэдээллийн эринийг цогцлоох зорилго замаасаа хазайх эрсдэл бий. Гэхдээ Монгол Улсын Засгийн газар "Цахим Монгол" хөтөлбөрийг 2012 он хүртэл хэрэгжүүлж, цаашид мэдээлэл, харилцаа, холбооны салбарыг төрийн бодлогын тэргүүлэх чиглэлд тулгамдсан асуудлууд дээрх хөтөлбөрийн хүрээнд шийдэгдэх найдлага төрүүлж байна.

Иймд ОНМХ-ийн ажилтнууд, сэтгүүлчид, сэтгүүл зүй сургалт явуулдаг их, дээд сургуулиуд Монгол улс "цахимжих" үйл явцыг гярхай ажиглан судлах, үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, боловсронгуй болгох, шинэчлэл дэвшил бүхнийг шуурхай тусган авах үүрэг хариуцлагыг хүлээж байна.

Үүгээр ч зогсохгүй, Монголын сэтгүүл зүй, ОНМХ-ийн үйл ажиллагааг чанаржуулан сайжруулах, гадаадын

мэдээллийн хэрэгслүүдээс туршлага судлах, суралцах, цаашилбал Монгол улс мэдээллийн эринд шилжих явцыг дэмжихэд цахим технологи, цахим сэтгүүл зүйн судалгаа, сургалт, нэгдсэн бодлого зайлшгүй шаардлагатай.

Иймд Монголд мэдээллийн аюулгүй байдал, хариуцлагыг зохицуулах хууль эрх зүйн тогтолцоог бүрдүүлэн боловсруулах үйлст сэтгүүлчид, холбогдох мэргэжлийн байгууллагууд шууд холбоотойгоор оролцох нь зүйтэй.

Мөн цахим сэтгүүл зүйг хөгжүүлэх, цахим эх сурвалжийг ашиглах талаар сэтгүүлчдэд сургалт явуулах, холбогдох их, дээд сургуулийн багш, эрдэмтэд судалгаа шинжилгээгээ өргөжүүлж гарын авлага, материаллаг баазын эх суурьтай болох, цаашлаад цахим сэтгүүл зүйг сургалтын хөтөлбөртөө нэвтрүүлэн энэ чиглэлд мэргэшсэн сэтгүүлчдийг бэлтгэхэд анхаарах шаардлагатай гэж үзэж байна.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. *Зулькафиль М.* 2005. Сэтгүүл зүйн тайлбар толь. УБ.
2. *Зулькафиль М.* 2007. Орчин үеийн сэтгүүл зүй. УБ.
3. *Норовсүрэн Л.* 2003. Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм. Гутгаар боть.
4. *Коханова Л.* 2007. Интернет-журналистика. Москва.
5. 2005. "Цахим Монгол" хөтөлбөр (2005-2012). МХХТГазар. УБ.
6. *Скотт Э.* 1999. Информационные технологии в журналистике. Москва.
7. *Toffler A.* 1980. The Third Wave. New-York.

Резюме

В статье "Интернет-журналистика Монголии: становление, развитие, перспективы" автор затрагивает вопросы о формировании информационного общества, развитии информационных технологий в Монголии. Также в данной статье особое внимание уделяется тому, как изменяется система СМИ Монголии в период глобали-

зации. Рассматриваются проблемы и возможные пути их решения в рамках национальной программы "Цахим Монгол", проводимой Правительством Монголии в 2005-2012 гг. для развития информационных технологий и онлайн-коммуникаций во всех сферах общества. Также автор поднимает вопрос об актуальности научных исследований, подготовки профессиональных кадров в данной области.